



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2012 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Далай ашиглах тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулах, “Монголын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” журмын төсөл боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Ж. Жамбажамц Далай ашиглалт, усан замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

М. Ганцэцэг Далай ашиглалт, усан замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Н. Энхбаатар Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга

Д. Ганбаатар Далай ашиглалт, усан замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн мэргэжилтэн

А. Тогосболд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн/

Б. Мөнхболд Далайн захиргааны орлогч дарга

2. “Далай ашиглах тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулах, “Монголын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” журмын төсөл боловсруулах ажлыг шуурхай зохион байгуулж, 2012 оны 4 дүгээр улиралд багтаан Засгийн хуралдаанд

танилцуулах, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг /Ё. Манлайбаяр/-т үүрэг болгосугай.

3. Монгол Улсын далайн салбарын үйл ажиллагааг сайжруулж өргөжүүлэх, Монгол Улсын далайн салбарт гадаад улс орнуудтай хамтран ажиллах чиглэлийг тодорхойлох талаар санал боловсруулж 2012 оны 4 дүгээр улиралд багтааж Сайдын зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэхийг ажлын хэсэг /Ё.Манлайбаяр/-т үүрэг болгосугай.

4. Далай ашиглах тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулах, “Монголын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” журмын төсөл боловсруулахтай холбогдон гарах зардлыг төсвийн дагуу санхүүжүүлэхийг Далайн захиргаа /Д.Галсандондог/-нд зөвшөөрсүгэй.

△ Гансүх А.ГАНСҮХ

